

2022 ЖИЛИЙН ТАЙЛАН

Хөгжилд Хамтдаа

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

I. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

II. КОМПАНИЙН ТҮҮХ

III. КОМПАНИЙН ТУХАЙ

Алсын хараа

Эрхэм зорилго

Үнэт зүйлс

Зарчим

Биржийн үйл ажиллагааны тойм

IV. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

ТУЗ-ийн хороодын чиг үүрэг, танилцуулга

2

3

4

5

5

5

5

6

6

7

7

8

9

V. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Журам, зохицуулалт

Шинэчлэгдсэн болон шинээр баталсан журмууд

Үндсэн үйл ажиллагаа

Арилжаа

Тооцооны үйл ажиллагаа

Бүртгэл

Гишүүнчлэл

Эрсдэлийн удирдлага

Бизнесийн үйл ажиллагаа

Судалгаа, хөгжүүлэлт

Хамтын ажиллагаа

Сургалт

Системийн хөгжүүлэлт

Хүний нөөц

VI. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

11

11

11

12

12

13

13

14

14

16

16

17

18

18

19

20

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

Бирж - “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК

СЗХ - Санхүүгийн зохицуулах хороо

ҮЦТХТ - Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

ХЭХ - Хувьцаа эзэмшигчдийн хурал

ТУЗ - Төлөөлөн удирдах зөвлөл

API - Application Programming Interface



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК (Бирж)-ийн Хувьцаа эзэмшигчид, нийт гишүүд, зах зээлийн мэргэжлийн оролцогчид та бүхний амар мэндийг эрэн мэндчилье.

Бирж нь 2021 онд үйл ажиллагаандаа шинэчлэл, rebranding хийснээр 2022 оноос олон улсын биржүүдийн жишгийн дагуу хотынхоо нэрээр нэрлэгдэх болж, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж нэрийн дор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах, түргэн шуурхай, найдвартай үйлчилгээг үзүүлэх бодлогын хүрээнд үргэлж шинийг санаачлан ажиллахаар зорьсон жил боллоо.

2022 онд Биржийн гишүүдийн тоо 22, тооцооны гишүүдийн нийт тоо 7 болж нэмэгдсэн бөгөөд гишүүддээ үзүүлэх хөнгөлөлт урамшууллын бодлогыг баталсан. Мөн компанийн стратеги бодлогыг дахин тодорхойлж, үндэсний үйлдвэрлэгчид баялаг бүтээгчдэд санхүүжилтийн шинэ хувилбарын хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдсээр байгаа энэ цаг мөчид хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгох ажлыг хурдасгах, зардлыг багасгах үүднээс IPO45 хөтөлбөрийг санаачилж, 2023 оноос хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ажлыг хангалаа.

Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд олон сорилтууд тулгарч байгаа ч бид зах зээлийн дэд бүтцийн байгууллагын хувьд тэдгээрт тохирсон уян хатан зохицуулалт, систем, үйл ажиллагааны болон стратеги бодлогын шинэчлэлүүдийг цаг тухай бүрд нь хийж, зах зээлийн оролцогчид болон бизнес эрхлэгчдэд таатай боломжуудыг бий болгох ажлыг тасралтгүй хийсээр байх болно.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг шинэ түвшинд хүргэх их үйлсэд бидэнтэй хамтран, үргэлж дэмжин ажилладаг эрхэм хувьцаа эзэмшигчид, зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагууд та бүхэнд талархал илэрхийлж байна.

Б.Гантулга
Гүйцэтгэх Захирал
“Улаанбаатар Үнэт
Цаасны Бирж” ХК

КОМПАНИЙН ТҮҮХ

2009

Насдак хамтын ажиллагааны төслийн зөвлөгөө авав.

2016

MSX Платформ Өөрсдийн арилжаа, тооцооны системийг нэвтрүүлэв.

2020

OTC/FX Судалгаа төсөл эхлүүлэв. Анхны бонд Минж пропертис ХК-г бүртгэв.

2022

УБҮЦБ Менежментийн болон дүрэм журмын шинэчлэлийг зохион байгуулав.

2008

Мосдак Дат Судалгаа төслийн үндэс тавигдав.

2015

МҮЦБ Үнэт цаасны арилжаа, тооцооны тусгай зөвшөөрөл авав.

2017

IPO Анд Энерги ХК Анхны хувьцаат компанийг бүртгэв.

2021

Rebranding Шинэ стратегийн хөрөнгө оруулагчтай болж, системийн шинэчлэлийг амжилттай дуусган, UBX платформыг нэвтрүүлэв.

КОМПАНИЙН ТУХАЙ



Эрхэм зорилго

Бүс нутгийнхаа хөрөнгийн зах зээлийн төв болох



Алсын хараа

Бүс нутгийнхаа хөрөнгийн зах зээлийн төв болох



Үнэт зүйлс

- Хурд
- Үр ашиг
- Засаглал
- Уян хатан бодлого
- Харилцагчийн нууцлал
- Мэргэжлийн ёс зүй

КОМПАНИЙН ТУХАЙ

Зарчим

- Хүний эрх, эрхэм чанарыг дээдэлж ажиллана;
- Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх төвшинд нэвтрүүлэн ажиллана;
- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллана;
- Нээлттэй уян хатан бодлого баримталж, зах зээлийн мэдрэмжтэй, хурдан шуурхай ажиллахыг эрмэлзэнэ;
- Хөрөнгийн зах зээлд шинэ, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, манлайлах бодлогыг мөрдөж ажиллана;
- Хууль эрх зүйн болон бизнесийн орчиндоо шаардагдаж буй өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө санаачилга гаргаж ажиллана;
- Харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцэх, найдвартай, аюулгүй, цахим систем, дэд бүтцийг нэвтрүүлэн ажиллана;
- Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг чандлан мөрдөнө;
- Хамгийн авьяаслаг, хүчирхэг, мэргэжлийн, үйл хэрэгтээ үнэнч хамт олныг бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг ямагт өндөрт тогтоон дагаж, хууль тогтоомжийг чандлан мөрдөж ажиллана;
- Нийгмийн хариуцлага өндөртэй, нийгэмд эерэг өөрчлөлтийг түүчээлэх, байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах чиг хандлагыг үйл ажиллагаандаа шингээж ажиллахыг эрхэмлэнэ.

КОМПАНИЙН ТУХАЙ

Биржийн үйл ажиллагааны тойм

22

Арилжааны гишүүд

7

Тооцооны гишүүд

2

Зах зээл үүсгэгч

Арилжаа, тооцоо: 2022 онд Биржийн зах зээлд 32,121,157 төгрөгийн арилжаа явагдаж, 1,328,500 төгрөгийн тооцоог гүйцэтгэсэн. Биржийн бус зах зээлд 4,193,987,223 төгрөгийн үнийн дүн бүхий бондын эргэн төлөлтийн тооцооны үйл ажиллагааг амжилттай хийж гүйцэтгэв.

Бүртгэл: Нэг компанийн нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн. Бүртгэлийн журамд өөрчлөлт орж ETF(хамтын биржээр арилжаалах хөрөнгө оруулалтын сан)-ийн арилжаа хийх боломжтой болж, үнэт цаасны компаниудад танилцуулга хийсэн. Хувьцаат компаниудын “Мэдэгдвэл зохих хэлцлийн удирдамж” болон “Компанийн засаглал хэрэгжүүлэх удирдамж”-ийг тус тус батлав.

Гишүүнчлэл: “Таван Богд Капитал ҮЦК” ХХК арилжаа болон тооцооны гишүүнээр “Новел Инвестмент ҮЦК” ХХК болон “Стандарт Инвестмент ҮЦК” ХХК нь арилжааны гишүүнээр, Ард Кредит ББСБ” ХК нь тооцооны ерөнхий гишүүнээр тус тус элсэж арилжааны гишүүдийн тоо 22, тооцооны гишүүдийн тоо 7 болов.

Маркетинг, хамтын ажиллагаа: Global banking and finance awards-с “Монголын хамгийн хурдан өсөлттэй хөрөнгийн бирж” шагнал хүртэв.

Систем: ҮЦТХТ-ийн шинээр нэвтрүүлэх гэж буй X-DEPO системтэй холбогдож арилжааны болон төлбөр тооцооны мэдээлэл солилцох ажлыг гүйцэтгэж, туршсан.

Компанийн засаглал: ТУЗ, менежментийн баг шинэчлэгдэж, компанийн шинэ стратеги болох “IPO 45” хөтөлбөрийг баталсан. Ёс зүйн дүрмийг шинэчлэн, залгамж халааны бодлогыг шинээр тус тус баталсан. Дотоод үйл ажиллагаатай холбогдуулан Дотоод журмын нэмэлт өөрчлөлтийг болон, архив албан бичгийн журмыг шинээр батлуулсан.

Хөрөнгө оруулалт татах: Стратегийн хөрөнгө оруулагч болохуйц ҮЦК-ууд, Банк, банк бус, аж ахуй нэгжүүд 30 орчим байгууллагад танилцуулга хийж, хамтын ажиллагааны боломжуудыг судалсан.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3 сарын 23-ны 145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсан. Үүний хүрээнд кодексийг хэрэгжүүлэхээр Компанийн засаглалын үнэлгээг хийж түүний дагуу төлөвлөгөө гарган шаардлагтай компанийн засаглалын журмуудыг баталж эхэлсэн бөгөөд компанийн засаглалыг зөв, үр нөлөөтэй зохион байгуулах тал дээр бэлтгэл ажлуудаа ханган ажиллалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Бирж нь нийт 28 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд Биржийн толгой компани болох “Даац инвестмент” ХХК 67 хувийг эзэмшдэг бол үлдсэн 33 хувийг 27 жижиг хувьцаа эзэмшигчид хуваан эзэмшиж байна.




График 1. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо
1	2022.04.18	98.2%	3
2	2022.07.27	80.69%	3

Хүснэгт 1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн стратеги төлөвлөгөө боловсруулах, төсөв батлах, хувьцаа эзэмшигчдийг хуралдуулах, үнэт цаас, ногдол ашигтай холбоотой шийдвэрүүд гаргах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин чиглүүлэх, санхүүгийн тайлан болон ил тод байдлыг хянах, охин болон хараат компанийн удирдлагыг хэрэгжүүлэх зэргээр ажиллана. ТУЗ нь хороодын байнгын үйл ажиллагааг нь ханган ажилладаг.


Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн




Ч.ГАНЗОРИГ
Гүйцэтгэх Захирал
"АрдЭкс ХХК"



Ч.НЯМДОРЖ
Гүйцэтгэх Захирал
"Тэргэл менежмент"
ХХК



Ө.АШХҮҮ
Хуульч
"Ард Менежмент ҮЦК"
ХХК



Ж.ЗОЛЗАЯА
ТУЗ-ийн гишүүн
"Ард Секюритиз ҮЦК"
ХХК



Б.ЗОЛБОО
Санхүү эрхэлсэн захирал
"Ард Санхүү Нэгдэл" ХК




С.ЦЭРЭН
Гүйцэтгэх Захирал
"Мон Чин" ХХК



Б.АНХБОЛД
Гүйцэтгэх Захирал
"Булигаар" ХК



Б.БАТСҮХ
Профессор
"Санхүү эдийн
засгийн их сургууль" ХК



О.ОДСАЙХАН
Салбар хариуцсан
захирал
"Хуавэй техноложис"



Ч.АНУН
ТУЗ-ийн нарийн бичгийн
дарга

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Биржийн хувьд 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04/22 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлэн сонгосон бөгөөд компанийн дүрмийн дагуу ердийн 6, хараат бус 3 гишүүнийг томилон ажиллууллаа. Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн холбогдох заалтад нийцүүлэн ТУЗ-ийн дэргэд дараах 3 байнгын хороод байгуулагдан ажиллаж байна. Үүнд, Аудитын хороо, Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо багтна.

ТУЗ-ийн хороодын чиг үүрэг, танилцуулга

Аудитын хороо

Аудитын хорооны дарга: Б.Анхболд

Аудитын хорооны гишүүд: Ц.Батсүх, Ч.Нямдорж

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь дотоод хяналтын тогтолцоог хянах, сайжруулах, аливаа эрсдэлийг тодорхойлон засах, санхүүгийн тайлангийн үнэн зөв, ил тод байдлыг хянан сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хянаж зөвлөмж гарган хөндлөнгийн аудиторуудтай хамтран ажиллах, дотоод хяналтын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх компанийн үйл ажиллагаа холбогдох хууль журмуудын дагуу явагдаж байгаа эсэхийг шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх ба ТУЗ-ийг чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх зорилготой.

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны дарга: О.Одсайхан

Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны гишүүд: Ө.Ашхүү, Б.Анхболд

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн бусад гишүүд болон албадын захирал зэрэг эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахад оролцох, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэлийг хянах, тэдгээрийн цалин урамшуулалыг нэмэгдүүлэхэд санал өгөх, компанийн засаглалын ил тод байдлыг сайжруулах талаар санал гарган ТУЗ-д танилцуулах, ТУЗ-с үүрэг болгосон бусад ажлуудыг гүйцэтгэх, засаглалын зарчмыг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих зорилготой.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Хөрөнгө оруулалт санхүү эрсдэлийн хороо

Хөрөнгө оруулалт санхүү эрсдэлийн хорооны дарга: Ж.Золзаяа

Хөрөнгө оруулалт санхүү эрсдэлийн хорооны гишүүд: Ч.Ганзориг, Б.Золбоо, О.Одсайхан

ТУЗ-ийн дэргэдэх Хөрөнгө оруулалт санхүү эрсдэлийн хороо нь хөрөнгө оруулалтын чиглэлээр компанийн стратегийн төлөвлөгөө боловсруулахад оролцох ба гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин төсөл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд эрсдэлийн урьдчилсан дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд удирдамж чиглэл өгөх үйл ажиллагаа эрхлэн явуулдаг.

Тайлант хугацаанд Биржийн ТУЗ 14 удаа хуралдсан бөгөөд дундаж ирц 84.8% байна. 2022 онд ТУЗ-өөс Биржийн үйл ажиллагаатай холбоотой нийт 30 тогтоолыг батлан гаргасан байна.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 4 удаа, Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо 2 удаа, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 4 удаа тус тус хуралдаж хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд зөвлөмж, дүгнэлтүүд гарган ажиллалаа.

№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо	№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо
1	2022.01.28	66.6%	1	8	2022.06.24	66.6%	3
2	2022.02.18	77.7%	3	9	2022.07.04	100%	1
3	2022.03.07	77.7%	1	10	2022.09.01	88.8%	2
4	2022.04.13	100%	3	11	2022.09.29	88.8%	1
5	2022.05.13	88.8%	3	12	2022.10.25	100%	2
6	2022.05.20	88.8%	2	13	2022.11.14	100%	1
7	2022.06.17	66.6%	2	14	2022.12.16	77.7%	5

Хүснэгт 2. ТУЗ-ийн үйл хурлын ирц, тогтоол

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Журам, зохицуулалт

Шинэчлэгдсэн болон шинээр баталсан журмууд

Биржийн хувьд 2022 онд дараах журам зохицуулалтуудыг баталж ажилласан.

Үүнд

- “Мэдэгдвэл зохих хэлцлийн удирдамж”
- “Компанийн засаглал хэрэгжүүлэх удирдамж”
- Бүртгэлийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл
- Нээлтийн үнэ тогтоох заавар
- Бүртгэлийн журмын нэмэлт өөрчлөлт
- Ёс зүйн дүрэм
- Залгамж халааны бодлого

Бирж нь СЗХ-оос 2022 оны 3 сарын 23-ны 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийг бүртгэлтэй үнэт цаас гаргагчид таниулах, засаглалыг сайжруулах ажлын хүрээнд “Компанийн засаглалыг хэрэгжүүлэх удирдамж” болон “Мэдэгдвэл зохих хэлцлийн удирдамж”-ийг тус кодекс болон олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан. Эдгээр удирдамжуудыг Биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 3 сарын 29-ны 15/22 тоот тушаалаар баталсан бөгөөд тухайн үнэт цаас гаргагч компани нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулах хугацаандаа компанийн засаглалыг сайжруулах, олон нийтэд мэдэгдэх шаардлагатай хэлцлийн талаарх ойлголтыг цогцоор авч болохуйц баримт бичиг юм. Түүнчлэн зөвхөн журам баталж мөрдүүлэхээс илүүтэй, эдгээр удирдамжуудыг боловсруулснаар үнэт цаас гаргагч тухайн журмуудыг хэрхэн дагаж мөрдөх, өөрсдийн үйл ажиллагаандаа хэрхэн нутагшуулахад чиглэл олгох давуу талтай.

Бүртгэлийн журмын өөрчлөлтийн гол агуулга нь Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргах өрийн хэрэгсэл нь Өрийн удирдлагын тухай хууль болон Хорооны өрийн хэрэгслийн бүртгэхтэй холбоотой журамд тавигдсан шалгуурыг хангасан байх, албан мэдэгдэл эсхүл үнэт цаасны танилцуулга бэлтгэх, танилцуулга бэлтгэх тохиолдолд чөлөөлөгдөх заалтуудыг тодорхойлох, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт болон эргэн төлөлтийн тайланг улирал бүр ирүүлэх тухай заалтуудыг нэмэлтээр оруулсан. Ингэснээр Биржээр дамжуулан аймаг, нийслэлийн гаргасан өрийн хэрэгслийг хялбаршуулсан зарчмаар бүртгэж, арилжих боломж бий болж байгаа юм. Түүнчлэн шинэчилсэн журмаар хөрөнгө оруулалтын сангийн нэг төрөл болох хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын санг бүртгэхтэй холбоотой зохицуулалтыг шинээр нэмж, тухайн сангийн активт тавигдах шаардлага, сангийн нэгж эрхийн хөрвөх чадварын үзүүлэлтийг хэмжих аргуудыг тодорхойлсон. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хувьд баталгаат болон барьцаат үнэт цаасны төрлөөс хамааруулан тавигдах нэмэлт шалгуур, баримт бичгүүдийн жагсаалтыг оруулсан. Дээрх нэмэлт, өөрчлөлтүүд нь хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчдад үнэт цаас гаргах үе шатыг тодорхой болгох, хөрөнгө оруулалт татах шинэ боломжуудыг нээж өгснөөрөө онцлог юм.

Компанийн засаглалын кодексийн шинэчлэлтэй уялдуулан байгууллагын удирдлага болон ажиллагсдын дотооддоо баримтлах, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах Ёс зүйн дүрмийг шинэчлэн баталлаа. Мөн компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, эрсдэлээс сэргийлэх зорилгоор Залгамж халааны бодлогыг ТУЗ-өөр батлууллаа.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үндсэн үйл ажиллагаа

Арилжаа

Тайлант хугацаанд анхдагч зах зээлд хувьцаа болон бондын арилжаа явагдаагүй. Хоёрдогч зах зээлд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 247 өдрийн арилжаа явагдаж, 1,224,200 ширхэг 32,121,157 төгрөгийн үнийн дүнтэй хувьцаа арилжигдсан байна. 2022 онд "Анд Энерги" ХК-ийн AND хувьцааны дээд ханш 57 төгрөг, доод ханш 23 төгрөг, дундаж үнэ 26.2 төгрөг, 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хаалтын ханш 27 төгрөг байлаа.


2022 оны хамгийн өндөр дүнтэй арилжаа явагдсан сар нь 9 дүгээр сар бөгөөд нийт 17,272,135 төгрөгийн үнийн дүнтэй арилжаа явагдсан байна.

2022 оны арилжаанд дараах үнэт цаасны компаниуд оролцсон бөгөөд хамгийн өндөр дүн бүхий арилжааг "Дэлгэрхангай Секюритиз ҮЦК" ХХК хийжээ.

№	ҮЦК-ийн нэр	Арилжааны дүн /төгрөг/
1	"Дэлгэрхангай Секюритиз ҮЦК" ХХК	42,604,300
2	"Ард Секюритиз ҮЦК" ХХК	20,257,714
3	"Бумбат-Алтай ҮЦК" ХХК	1,380,300

Хүснэгт 4. Хувьцааны хоёрдогч зах зээлд оролцсон үнэт цаасны компаниудын идэвх

Арилжааны гишүүдийн тоо



Арилжааны бодит цагийн болон арилжааны дараах өдөр тутмын мэдээллийг бид www.ubx.mn цахим хаягаар дамжуулан олон нийтэд тогтмол хүргэж байна. Мөн дотоод мэдээлэл эзэмшигчид болон арилжаанд оролцогч бусад этгээдүүд зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх үүднээс үнэт цаасны компаниуд болон үнэт цаас гаргагчтай хамтран арилжааны хяналтыг гүйцэтгэж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тооцооны үйл ажиллагаа

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК нь 2022 онд биржээр арилжаалсан үнэт цаасны төлбөр тооцооноос гадна 2019 оноос өмнө төлбөр тооцоо хийлгэхээр бүртгэгдэн, биржийн бус зах зээлд арилжаалсан бондын төлбөр тооцоог мөн хийж гүйцэтгэлээ. Биржийн зах зээлд нийт 317 хэлцэл хийгдэж, эмхэтгэсэн дүнгээр 1,328,500.00 төгрөгийн үнийн дүн бүхий тооцооны, биржийн бус зах зээлд бондын 4,193,987,223.36 төгрөгийн үнийн дүн бүхий эргэн төлөлтийн тооцооны үйл ажиллагааг 2022 онд хийж гүйцэтгэв.

Биржээр арилжаалсан үнэт цаасны төлбөр тооцооны үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харууллаа.

Тооцооны гишүүн	Тооцооны гишүүний төрөл	Үнэт цаасны тикер	Тооцооны дүн, ₮
Харз трейд ББСБ	ТЕГ	AND	977,000
Ард Секюритиз ҮЦК	ТШГ	AND	1,328,500
Бумбат-Алтай ҮЦК	ТШГ	AND	351,500

Хүснэгт 5. Биржийн хэлцэл /эмхэтгэсэн дүнгээр/

Тооцооны гишүүдийн тоо



2022 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар Үнэт Цаасны Бирж нь 3 тооцооны ерөнхий гишүүн, 4 тооцооны шууд гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бүртгэл

Бид энэ онд Биржийн “Бүртгэлийн журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг СЗХ-оор батламжлууллаа. Тус журмыг СЗХ-ны 2022 оны 275, 360 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” болон “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-д орсон нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн, хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан /ETF/-г бүртгэхтэй холбоотой зохицуулалтыг шинээр нэмж оруулсан ба тухайн сангийн хөрвөх чадварыг хэмжих аргуудыг тодорхойлоход голчлон анхаарч ажилласан.

Бирж нь бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, материал, ТУЗ-ийн хурлын зар, материалыг хүлээн авч, шаардлагатай тохиолдолд үнэт цаас гаргагчдаас бусад мэдээллээ ирүүлэхийг шаардаж ажилласан. Биржийн систем, журмуудын шинэчлэлтэй холбоотойгоор хэрэгцээт мэдээллийг бүртгэлтэй үнэт цаас гаргагчдад тухай бүр хүргэж ажиллаж байна.

Бирж бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх үүднээс Бүртгэлийн хороо болон Нийцүүлэгчийг бүртгэлийн үйл ажиллагаанд оролцуулдаг. Биржийн Бүртгэлийн хороонд 2022 оны байдлаар нийт 12 гишүүн бүртгэлтэй байна. Эдгээр гишүүд нь ажиллаж буй салбартаа 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн болон ёс зүйн хариуцлагатай, хараат бус гишүүд байна. Биржийн бүртгэлийн шаардлагын дагуу бирж дээр бүртгэгдсэн компаниуд нийцүүлэгчээр дамжуулан зах зээлд тогтмол мэдээ гаргадаг нь бидний давуу талын нэг юм. Нийцүүлэгчид нь СЗХ-оос Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө эсвэл аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд байдаг. 2022 оны байдлаар Биржид 12 санхүүгийн нийцүүлэгч, 17 хуулийн нийцүүлэгч бүртгэлтэй байна.

Бирж үнэт цаас гаргагчид зөвлөгөө өгөх үүргийнхээ хүрээнд шинээр үнэт цаас гаргах зорилготой 10 гаруй компанитай уулзалт зохион байгуулсан. Мөн Биржид үнэт цаас бүртгүүлэх сонирхолтой компаниудад бүртгэлийн шалгуур, үе шат, баримт бичгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий танилцуулга илгээж ажиллалаа.

Гишүүнчлэл

Бирж нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 22 арилжааны гишүүн, 4 тооцооны шууд гишүүн, 3 тооцооны ерөнхий гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд 3 үнэт цаасны компани Арилжааны гишүүнээр элсэж, 1 арилжааны гишүүн Тооцооны ерөнхий гишүүн, 1 арилжааны гишүүн Тооцооны шууд гишүүний гэрээ байгууллаа.

2022 онд Биржийн гишүүдэд шинэчлэгдсэн болон шинээр батлагдсан журмын танилцуулгыг цахим уулзалтаар дамжуулан хүргэж, журмын нэмэлт, өөрчлөлтүүдэд гишүүдийн саналыг авч тусгасан.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрсдэлийн удирдлага

Арилжааны эрсдэлийн удирдлага

Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэхийн тулд биржийн арилжааны систем нь дотоод мэдээлэл эзэмшигчдийг бүртгэж, дотоод мэдээлэл эзэмшигчийн дансаар хийгдсэн захиалга болон хэлцлийн жагсаалтыг биржийн арилжааны дансаар салгаж харуулдаг. Ингэснээр хяналт, шалгалтыг бодит цагийн горимоор болон арилжааны дараа хийх боломжтой болсон.

Тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Бирж нь 2022 онд тооцооны үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлэх үүднээс тооцооны гишүүдээс барьцаа, дэнчингийн доод үлдэгдлийг журамд заасны дагуу тогтмол хангуулж ажиллалаа. Арилжаанд оролцож буй оролцогчдын байршуулах дэнчингийн хувь хэмжээг 20 хувиас доошгүй байхаар, барьцаа хөрөнгийн доод үлдэгдлийг тогтмол дүнгээр Тооцооны ерөнхий гишүүд 10,000,000 төгрөг, Тооцооны шууд гишүүд 2,000,000 төгрөг байхаар тогтоосон. 2022 оны байдлаар тооцооны гишүүд төлбөрийн чадварын эрсдэлд орсон тохиолдол гараагүй байна.

Бизнесийн үйл ажиллагаа

Хөрөнгийн зах зээлийн хувьд шинэ санхүүгийн бүтээгдэхүүнээр цангаж байгаа бөгөөд СЗХ-оос энэхүү боломжуудыг олгохоор зохицуулалтын орчинд олон шинэчлэл өөрчлөлтүүдийг хийсэн. Биржийн хувьд ч мөн эдгээр дүрэм, журмын хүрээнд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхээр олон улсын зах зээлийн судалгааг тогтмол хийж, шинэ боломж, үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхээр ажилладаг бөгөөд 2022 оны хувьд ETF (хамтын биржээр арилжаалагдах сан) REIT (Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэлцэл) зэрэг бүтээгдэхүүнийг Монголын зах зээлд нэвтрүүлэх судалгааг хийгээд байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Судалгаа, хөгжүүлэлт

Шинэ бүтээгдэхүүн судалгаа, хөгжүүлэлт

ETF олон улсын судалгаа хийж, Монгол улсад бүтээгдэхүүн гаргахаар оролцогч талууд болон кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд, үнэт цаасны компаниудтай уулзалт хийж, бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эдийн засгийн зөвлөхийн хүсэлтээр хөрөнгийн зах зээлийн эмэгтэй бүтээгдэхүүний талаар судалгаа хийж, мэдээлэл хүргүүлсэн.

Олон улсын хамтын ажиллагаа

World federation of exchanges болон Sustainable Stock Exchange зэрэг олон улсын биржүүдийн холбооноос зохион байгуулдаг ажлуудад идэвхитэй оролцон, олон улсын туршлага судлан ажиллаж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Судалгаа, хөгжүүлэлт


Монголын хамгийн хурдан өсөлттэй хөрөнгийн бирж шагнал

Олон улсын банк санхүүгийн салбарт тасралтгүй судалгаа шинжилгээ хийж, хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээллийг хүргэдэг дэлхийн нэр хүндтэй сэтгүүл болох "Global Banking & Finance Review" сэтгүүлээс жил бүр тодруулдаг "Global Banking & Finance Awards 2022"-с "Fastest Growing Stock Exchange Mongolia" буюу "Хамгийн хурдацтай хөгжиж буй хөрөнгийн бирж 2022" шагналыг "Улаанбаатар Үнэт Цаасны Бирж" ХК хүртсэн.



ТОП 100 аж ахуй нэгжийн судалгаа

МҮХАҮТ, Монголын хөрөнгийн биржтэй хамтран ТОП 100 аж ахуй нэгжээс хөрөнгийн зах зээлд гарах судалгаа авсан.



IPO 45 хөтөлбөр

Тайлант хугацаанд Биржийн удирдлагад өөрчлөлт орж, шинэ гүйцэтгэх захирал томилогдсон бөгөөд Компанийн стратеги төлөвлөгөөг дахин тодорхойлж, үнэт цаас гаргагч компаниуд, үнэт цаасны компаниудад хөнгөлөлт урамшууллыг үзүүлэх, хөрөнгийн зах зээлээ хөрөнгө босгох үйл ажиллагааны хугацааг богиносгох, зардлыг хэмнэх зорилгоор IPO 45 хөтөлбөрийг батлан гаргасан.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хамтын ажиллагаа

- “Санхүүгийн зах зээлийн шинэ сорилтууд ба боломж” симпозиумд Хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц сэдвээр оролцсон.
- Грэйпсита компанийн хөгжүүлсэн КАСПО системийг биржийн гишүүн үнэт цаасны компаниудад 2023 оны эхний улиралд үнэ төлбөргүй ашиглуулахаар болов.
- Хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагуудтай хэд хэдэн удаагийн уулзалт, хамтарсан үйл ажиллагааг зохион байгуулав.




Сургалт

2022 оны байдлаар дараах сургалтуудыг зохион байгуулж, үнэт цаасны зах зээлд оролцож санхүүжилт босгох, хөрөнгө оруулахаар сонирхож буй хувь хүмүүст хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг олгосон. Үүнд:

- Хөрөнгө оруулагч үндэстэн форумд “Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломж” сургалт
- Арилжаа эрхлэгчдийн холбоо, Монгол банк хамтарсан хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох сургалтын хүрээнд “Хувьцаа, бондын ялгаа” сургалт
- Хүнс хөдөө аж ахуйн яамнаас зохион байгуулж буй экспортыг дэмжих төслийн хүрээнд оролцогч аж ахуй нэгжүүдэд “Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломж” сургалт уудыг тус тус орсон.

СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ

UBX платформын захиалга хүлээн авах хүчин чадал, тулгалт хийх хурд болон мэдээллийн аюулгүй байдал, тогтвортой, найдвартай үйл ажиллагааг хэвийн явуулахаар системийн хөгжүүлэлт, сайжруулалтуудыг өдөр тутамдаа хийж ирсэн. UBX платформ нь зах зээлд хэд хэдэн давуу талыг мэргэжлийн оролцогчдод олгож байна. Тухайлбал: ҮЦТХТ дээр данс бүхий бүх харилцагч нар тухайн дансаа ашиглан Биржийн арилжаанд оролцох боломжтой. Мөн мэргэжлийн оролцогчдод гаргаж өгсөн API-ууд нь Үнэт цаасны компаниудын үйл ажиллагааг цахимжуулах, тэдгээрийн зардлыг бууруулах боломж олгохоос гадна маржин арилжаа, short sell арилжаа, болон бусад шинэ бүтээгдэхүүнийг аливаа нэмэлт зардалгүйгээр хийх технологийн шийдлийг агуулсан болно. ҮЦТХТ-ийн шинээр нэвтрүүлэх гэж буй X-DEPO системтэй холбогдож арилжааны болон төлбөр тооцооны мэдээлэл солилцох ажлыг гүйцэтгэж, туршилтыг хийж дуусгаад байна.



ХҮНИЙ НӨӨЦ

“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК нь 2022 онд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу “Дотоод журам”-г шинэчлэн баталж ажиллаж байна.


Ажилтны ур чадварыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, компанийн зөв зохистой соёлыг төлөвшүүлэх бодлого баримтлан ажилладаг бөгөөд баг хамт олноо бүрдүүлэхдээ чадварлаг, авьяаслаг, ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг залуусыг сонгон ажиллуулдаг. Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байсан ч ажиллагсдаа хувийн тэтгэврийн дансны хуримтлал болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамруулан ажилладаг. Мөн их сургуулийн төгсөх курсын оюутнуудыг дадлагажуулах, ажлын туршлага олгох зорилгоор дадлагажигч оюутны хөтөлбөрийг 2 дахь жилдээ хэрэгжүүлсэн бөгөөд залуу үеэ дэмжиж, хөрөнгийн зах зээлийн салбарт залуу, чадварлаг боловсон хүчнүүдийг бэлтгэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



Б.ГАНТУЛГА
Гүйцэтгэх Захирал
“Улаанбаатар Үнэт
Цаасны Бирж” ХК



О.БАРСҮРЭН
Мэдээлэл
технологийн газрын
захирал



М.ДАВААЖАРГАЛ
Бизнес хөгжил,
захиргааны газрын
захирал



Б.Баяржаргал
Зах зээлийн үйл
ажиллагааны газрын
захирал



Б.Буянхишиг
Зөвлөх

VI. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК 2022 онд нийт 32,121,157 төгрөгийн арилжаа хийж, арилжаа тооцооны шимтгэлд 463 мянган төгрөгийн орлого, 6 сая төгрөгийн бүртгэл хураамжийн орлого, бусад үйл ажиллагааны орлогоор 212 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар компанийн балансын нийт хөрөнгийн дүн 2.42 тэрбум төгрөг бөгөөд үүний 16 хувийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна.

Дүн (сая төгрөгөөр)

№	Санхүүгийн тайлангийн хураангуй үзүүлэлтүүд	Дүн (сая төгрөгөөр)	
		2021.12.31-ны үлдэгдэл	2022.12.31-ны үлдэгдэл
1	Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүд		
1.1	Борлуулалтын орлого	7.86	6.46
1.2	Борлуулалтын өртөг	-	0.17
1.3	Нийт ашиг	7.86	6.29
1.4	Хүүний орлого	0.00	0.00
1.5	Бусад орлого	0.47	0.21
1.6	Ерөнхий ба удирдлагын зардал	1,045.81	1,128.39
1.7	Санхүүгийн зардал	22.75	57.16
1.8	Бусад зардал	303.13	-
1.9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.06
1.10	Хөрөнгө оруулалт / Үндсэн хөрөнгө борлуулснаас үүссэн олз (гарз)	10.06	(15.21)
1.11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,353.28)	(1,194.19)
1.12	Орлогын татварын зардал	(41.84)	13.00
1.13	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,311.45)	(1,207.19)
2	Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд		
2.1	Нийт хөрөнгийн дүн	4,134.86	2,418.62
2.2	Үүнээс: Эргэлтийн хөрөнгийн дүн	1,676.12	380.57
2.3	Өр төлбөрийн дүн	638.87	753.35

Хөгжилд Хамтдаа

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 1309 тоот

Утас: 70000501, 70000502

Email: info@ubx.mn

